

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2023 оны 01 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

1	2		3	4	5	6
Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар		Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6	7
Монгол Улсын хууль						
1	1 (10)	63.2. Албан хаагчийн дүрэмт хувцасны загварыг эдэлгээний хугацаа, хэрэглэх журмын хамт Ерөнхийлөгч, Засгийн газар тус тогтооно.	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	Байгууллагын даргын 2021 оны “Албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх тухай” А/82 дугаар тушаалыг батлан, хэрэгжүүлж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцүүлэн 2022 онд улсын байцагч нарт 3411 ширхэг хар цагаан цамц, зангиа, хавар, өвлийн гутал, өдөр тутмын хүрэм олгосон.	100	
	2 (11)	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.		“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 47 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр баталж, 93.6 хувьтай хэрэгжилтийг ханган ажиллав. Албан хаагчдад зэрэг дэв олгуулах хүсэлтийг 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/346 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, 01/345 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлж, дэс түшмэлийн тэргүүн 7, дэд 24, гутгаар 17, дөтгөөр 5, нийт 53 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан батлуулсан. Байгууллагын даргын 2022 оны Б/70 дугаар тушаалаар нийт 67 албан хаагчийн цалингийн шатлалыг шинэчлэн тогтоож, "А буюу маш сайн" үнэлэгдсэн 7 албан хаагчийн	100	

1	2		3	4	5	6
				<p>шатлалыг алгасуулж, "В буюу сайн" үнэлэгдсэн 60 албан хаагчийн шатлалыг ахиуллаа.</p> <p>"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөө"-ний хүрээнд мэргэшил дээшлүүлэх, суралцах боломжийг хангах зорилгоор байгууллагын даргын 19 удаагийн тушаалаар 15 албан хаагчид цалинтай, 4 албан хаагчид цалингүй чөлөө олгож, хяналтын улсын байцаагчийн хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны урамшуулалд хамрагдах эрх үүссэн 17 албан хаагчийн мөнгөн урамшууллыг олгосон байна.</p> <p>Байгууллагын даргын 03 дугаар сарын 28-ны өдрийн А/50 дугаар тушаалаар төв, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны зардлын нөхөх төлбөрийг 15,000 төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.</p> <p>Сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагын даргын 2022 оны Б/32 дугаар тушаалаар байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан нийт 17 ахмад настанд тус бүр 200,000 төгрөг буюу нийт 3,400,000 төгрөгийн дэмжлэг тусламж үзүүлэв.</p> <p>"Гадаадын иргэн, харьяатын газрын сургалтын 2022 оны төлөвлөгөө"-г 01 дүгээр сарын 28-ны өдөр батлан, төлөвлөгөөний хүрээнд 45 удаагийн сургалтад давхардсан тоогоор 2521 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Бүгд Найрамдах Энэтхэг Улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 албан хаагчийг, төрийн болон бусад байгууллагатай хамтран төрийн албан хаагчийн "Мэргэшүүлэх багц сургалт" болон "Алсын хараа 2050", "Цахим хөгжлийн багц хууль", "Кибер аюулгүй байдал", "Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал" зэрэг 36 удаагийн сургалтад давхардсан тоогоор 289 албан хаагчийг тус тус суралцууллаа.</p>		
2	3 (35)	8.1.2. Монгол Улсад байгаа гадаад улсын иргэн буцах хүсэлт гаргасан тохиолдолд улсын хилээр нэвтрүүлэх талаар холбогдох шийдвэр гаргах; (8.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх,	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 193 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам"-д зааснаар Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэр гарсан боловч 12 дугаар сарын 10-ны өдрийн	100	

1	2		3	4	5	6
		талаар Улсын онцгой комисс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29	байдлаар 1 улсын 4 иргэн Коронавируст халдвар /КОВИД-19/-ын нөхцөл байдлаас шалтгаалан улсын хилээр гараагүй байна. Албадан гаргахаар шийдвэрлэсэн дээрх гадаадын иргэдийг нутаг буцаахад дэмжлэг үзүүлэх талаар Гадаад харилцааны яам болон холбогдох Элчин сайдын яаманд уламжлуулах тухай хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/577 дугаар албан бичгээр хүргүүлсэн.		
	4 (38)	9.7. Цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын хилээр оруулахгүй байж болно.		Тайлант хугацаа (2021 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг дуустал)-д виз, визийн зөвшөөрөлгүй, ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй болон түргэвчилсэн шинжилгээгээр эерэг гарсан зэрэг үндэслэлээр нийт 23 улсын 2027 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулахгүй буцаасан. Үүнээс: Хойд бүс дэх газар түргэвчилсэн шинжилгээгээр эерэг гарсан 3 гадаадын иргэн Монгол Улсын хилээр оруулахгүй буцаажээ.	100	
	5 (43)	9.14. Хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм тогтоосны улмаас гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй, оршин суух зөвшөөрөл аваагүй, визийн болон оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүй бол тус нөхцөл байдал арилах хүртэл хугацаанд бүртгэл, хугацаа хэтрүүлсний төлбөр, торгуулиас чөлөөлнө.		Тайлант хугацаа (2021 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг дуустал)-д Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн, мөн визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэнээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан, гадаадын 5446 иргэний Монгол Улсад байх хугацааг 30 хүртэл хоногоор тухай бүр сунгаж, бүртгэл, хугацаа хэтрүүлсний төлбөр, торгууль тавигдаагүй байна.	100	
Хэсгийн дундаж хувь 100						
УИХ-ын тогтоол						
3	6 (134)	ХЗДХЯ УИХ-ын тогтоолын төсөл 2021. Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй	Гадаадын иргэн, харьяатын газраас “Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг холбогдох танилцуулгын хамт 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1730 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад уламжилсан.	100	

1	2		3	4	5	6
			болгох үндсэн чиглэл батлах тухай 2021-01-22 Дугаар 2021 №12	2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Монгол Улсад цагаачлан оршин суугч нийт 1908 гадаадын иргэн байгаа нь хүн амын 0.056 хувь, үүнээс хамгийн их буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн 1266 байгаа нь 0.037 хувь буюу Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан тоонд хүрээгүй байна.		
Хэсгийн дундаж хувь 100						
Ерөнхийлөгчийн зарлиг						
4	7 (176)	3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46	Байгууллагын гаднах хаяг, туг, байгууллагад ашиглаж буй 1 тамга, 1 тэмдэг, боомт, орон нутаг дахь нэгж тус бүрийн албаны байрны гаднах хаяг, нийт 7 тэмдэг, албан хаагчдын ялгах тэмдэг (жетон, ханцуй, малгайн бэлгэ, тэмдэг)-т үндэсний бичгийг оролцуулсан бичиглэлтэй байна. “Дэлхийд ганц босоо зурлагатай монгол бичгээ хамтдаа сурцгаая” аяны хүрээнд Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сарын 28-ны өдөр баталж, биелэлтийг 11 дүгээр сарын 21-ний өдөр тооцон тайлан гаргалаа. Үйл ажиллагааны хүрээнд байгууллагын 2022 оны цаг тооны хуанли дахь бичвэрийг кирилл, монгол бичгээр хослуулан бичиж, хэвлүүлсэн. “Монгол бичиг”-ийн сорилд 51 албан хаагчийг хамруулан мэдлэгийн түвшингээр эрэмбэлж, “Дархан энх оршихуй” сургалтын төвтэй хамтран 04 дүгээр сард “Монгол бичиг”-ийн анхан, дунд шатны танхимын сургалтыг зохион байгуулж, нийт 36 албан хаагчийг хамруулсан. Агаарын замын боомт хариуцсан газар 04, 05 дугаар сард, Баруун бүс дэх газар 05 дугаар сард “Монгол бичгийн хичээл”-ийг тус бүр зохион байгуулсан бол Зүүн бүс дэх газар 01 дүгээр сараас эхлэн албан хаагчдыг 7 хоног тутам, Дорноговь аймаг дахь газар 04, 05 дугаар сард 3 дахь жилдээ зохион байгуулж албан хаагчдаа хамруулжээ. Монгол-Шведийн хамтарсан эх хэл соёлыг хөгжүүлэх төвтэй хамтран 09 дүгээр сараас эхлэн Баян-Өлгий аймаг	100	

1	2		3	4	5	6
				<p>дахь хэлтэс албан хаагчдаа үндэсний бичгийн сургалтад суралцуулж эхлэв.</p> <p>“Монгол бичиг-III” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Үндэсний бичиг, үсгийн баяр”-ыг тохиолдуулан Дорноговь аймаг дахь газрын 19 албан хаагч “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийг Монгол бичигт хөрвүүлснийг байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулж, олон нийтэд сурталчиллаа.</p> <p>Байгууллагын төв болон орон нутаг дахь нэгжүүд албан өрөөнүүдийн хаягийг Үндэсний бичигт хөрвүүлэн шинэчилж, Баруун бүс дэх газар нийт компьютерт, Зүүн бүс дэх газар архив-бичиг хэргийн эрхлэгчийн ажлын компьютерт монгол бичгийн үсгийн программ суулгав.</p> <p>Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар нь үндэсний бичгийн сургалтыг 11 дүгээр сард танхимаар зохион байгуулж, Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан “Үндэсний бичигтэн 2022-2024 хөдөлгөөн”-ий нээлтийн арга хэмжээнд тус газраас 5 албан хаагч оролцлоо.</p>		
5	8 (184)	1.5. Иргэн, аж ахуйн нэгжийн тарьсан модоор ойн санг бүрдүүлж, түүнийг улсын нэгдсэн санд бүртгэх, тарьсан модыг зах зээлийн эргэлтэд оруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахад нь бодит дэмжлэг үзүүлэх болон гадаад улсаас Монгол Улсад ирж буй хүн бүр монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	Монгол Улсад оршин суух зөвшөөрөл хүссэн болон бүртгэл хийлгэж буй гадаадын иргэдэд Монгол оронд мод тарих тухай зөвлөмж, мэдээллийг уриалга хэлбэрээр хүргэж байна.	100	
	9 (185)	2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.		Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсад төвтэй “Ногоон Ази” төрийн бус байгууллагын дэмжлэгээр 300 модны суулгацыг хүлээн авсан. Төв байгууллага болон орон нутаг дахь нэгжүүд харьяалах нутаг дэвсгэртээ нийт 6 төрлийн 575 ширхэг мод, сөөг тарьж, тогтмол усалгаа, арчилгааг хийж байна. Үүнээс онцолбол, Хойд бүс дэх газар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн Сэлэнгэ аймгийн Шаамар сумын нутаг дэвсгэрт 22500 м2 газрыг хашаалж байгууллагын нэрэмжит төгөл байгуулан 4 төрлийн 165	100	

1	2		3	4	5	6
				ширхэг мод (агч 50 ширхэг, монос 30 ширхэг, интоор 25 ширхэг, үхрийн нүд 60 ширхэг) тарьж арчилж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин Агаарын замын боомт хариуцсан газраас Төв аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран тус газрын нэрэмжит төгөл байгуулах ажлыг эхлүүллээ.		
6	10 (189)	2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу 08 дугаар сарын 19-ний өдөр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн заллаа.	100	
	11 (190)	4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.		Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид төрт ёсыг дээдлэн хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100	
Хэсгийн дундаж хувь 100						
ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл						
7	12 (212)	5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус үүрэг болгосугай.	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	Засгийн газрын 2020 оны “Агаарын замын боомтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 183 дугаар тогтоолоор нийслэлийн Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал дахь агаарын замын хилийн боомт, хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшгийн хөндий дэх “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-д шилжүүлсэнтэй холбогдуулан Агаарын замын боомт хариуцсан газрыг шилжүүлэн нүүлгэх ажлыг 2021 оны 07 дугаар сараас үе шаттайгаар хэрэгжүүлж, Улаанбаатар хотод төвлөрч байсан төв болон Агаарын замын боомт хариуцсан газрын албан хаагчдын 21.2 хувийг орон нутагт ажиллуулах болсон.	100	

1	2		3	4	5	6
				Байгууллагын нийт албан хаагчдын 72.2 хувь нь орон нутаг дахь нэгжид харьяалагдаж, тухайн хилийн боомт, орон нутагтаа байнга оршин сууж байна.		
Хэсгийн дундаж хувь 100						
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл						
8	13 (236)	ХҮИИ.2.7. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бэлтгэл хангах арга хэмжээ авах, үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хөтөлбөр боловсруулж батлуулан ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт;	2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран “Гадаадын ажиллах хүч, цахим виз, хөрөнгө оруулалт хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар санал солилцох нь” сэдэвт уулзалтыг 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгууллаа. Уулзалтад Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллага, Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, аялал жуулчлал, бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл нийт 150 хүн оролцов. Уулзалтыг NTV, TV9, MN25, MYOHT зэрэг 11 телевиз, 2 сонин, 8 сайтаар олон нийтэд сурталчилсан. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Монголын аялал жуулчлалын холбоо, Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Tourism time” арга хэмжээнд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга нар цахим виз, хилийн боомтод олгож буй визийн зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл хүргэж оролцлоо. Байгууллагын дарга Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын тоог нэмэгдүүлэх, гадаадын иргэдэд хүргэх үйлчилгээг хялбаршуулах зорилгоор нэвтрүүлж буй цахим виз, хил орчмын аялал жуулчлалын виз, олон улсын хилийн боомтод олгох жуулчин ангиллын визийн талаар 10 дугаар сарын 05-ны өдөр ярилцлага, мэдээлэл өгөв. Ярилцлагыг ikon.mn, gogo.mn, tsahiur.mn, news.mn, zuv.mn, ubn.mn, zindaa.mn зэрэг 15 сайтаар олон нийтэд мэдээллээ. Мөн Vip Expert сэтгүүлийн 2022 оны 10 дугаар сарын буюу намрын дугаарын “Vip зочин” буланд цахим	100	

1	2	3	4	5	6	
			шилжилтийн үйл явц, үр дүн, хэтийн зорилгын талаар ярилцлага нийтлүүлээ.			
9	14 (256)	Х.11.2. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54	Хууль зүй, дотоод хэргийн яаманд байгуулагдсан “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байгууллагын Зөрчил, шалган шийдвэрлэх газрын дарга ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг ашиглалтад оруулаагүй болно.	100	
	15 (257)	Х.11.3. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг ашиглахтай холбоотойгоор эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтыг Улсын ерөнхий прокурорын газартай хамтран зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт;		“Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг ашиглаж эхлээгүй тул тайлант онд холбогдох байгууллагаас сургалт зохион байгуулаагүй болно.	100	
9	16 (260)	XXI.1.2. Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа болон гадаад томилолтыг хориглох, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, тэдгээрийг томилох эрх бүхий этгээдэд;	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/318 дугаар тушаалаар батлагдсан “2022 оны худалдан авах төлөвлөгөө”-ний дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 2 ажил үйлчилгээ, урсгал төсвийн хөрөнгөөр санхүүжих 8 бараа, ажил үйлчилгээний үйлчилгээний сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Тайлант онд төсвийн хөрөнгөөр гадаад томилолт болон шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулаагүй болно. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу байгууллагын дэд даргын орон тоог хасаж, урсгал зардлыг хэмнэн ажиллав.	100	
Хэсгийн дундаж: 100 хувь						
Нийт дундаж 100 хувь						